

ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГСӨГЧДИЙН УР ЧАДВАРЫГ АЖИЛ ОЛГОГЧДЫН ОРОЛЦООТОЙ ҮНЭЛЭХ НЬ

Жүгдэрнамжил Эрхэмтөгс¹, Бямбаа Баярмаа², Гомбодорж Баярмөнх³

¹ Соёл урлагийн их сургууль

² Соёл урлагийн их сургууль, Бүтээлч үйлдвэрлэлийн инновацийн төв

³ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын бодлого төлөвлөлтийн судалгааны сектор

Өгүүллийн мэдээлэл

Түүх:

Хүлээн авсан: 2023.07.18

Засаж сайжруулсан:

2023.09.04

Хэвлэхийг зөвшөөрсөн:

2023.09.05

Түлхүүр үг:

төгсөгчдийн ерөнхий ур чадвар, ажил олгогчид, ур чадварын түвшин

Холбоо барих зохиогч:

Гомбодорж Баярмөнх

Боловсролын судалгааны

үндэсний хүрээлэн,

Боловсролын бодлого

төлөвлөлтийн судалгааны

сектор

Email:

bayarmunkh@mnier.mn

Хураангуй

Их дээд сургуулийн төгсөгчдийн ур чадвар нь ажил олгогчдын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодруулах зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүн хамрагдсан. Судалгааны түүвэрлэлтийг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж асуулгыг дэс дараалалтай, бөглөхөд хялбар байлгах зарчмыг баримтлан олон хэмжээст үнэлгээний аргыг ашиглаж хийсэн. Их дээд сургууль төгсөгчдийн ур чадварыг ажилтан үр бүтээлтэй ажиллахад шаардлагатай нийтлэг чадамж, ур чадваруудын 15 үзүүлэлтээр үнэлж, үр дүнг 5 интервалд багцалж нэгтгэлээ. Судалгааны мэдээллийг статистикийн программ хангамжаар боловсруулж, үр дүнг жигнэсэн дунджийн аргыг ашиглан чанарын үнэлгээ хийлээ.

Ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин, төгсөгчдийн өнөөгийн ур чадварын түвшин гэсэн байдлаар үнэлж, их дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын зөрүүг нэгтгэн шинжилсэн. Ерөнхий ур чадвар буюу орчин үеийн мэдлэгт суурилсан нийгэмд шаардагдах ур чадварын цогц, ажилтан үр бүтээлтэй ажиллахад амин чухал нийтлэг чадамж, ур чадварууд судалгааны үр дүнгээр ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин (4.13-4.97), байгаа бол их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын өнөөгийн байдал гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88), зэргийн хувьд хангалтгүй, харин бусад ур чадваруудын хувьд дундаж буюу 3.16-3.9 байдаг гэж гарсан. Иймд их дээд сургууль төгсөгчдийн ур чадварыг ажил олгогчдын эрэлтэд нийцүүлэхийн тулд сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын чанарын үнэлгээ хийх зэрэг үйл явцад ажил олгогчдын хөндлөнгийн оролцоог хангах хууль зүйн орчин болон эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх аргаар тэдний идэвх санаачилгыг дэмжих, сургууль, ажил ологчдын хамтын үйл ажиллагааг бий болгох нь чухал байна.

Evaluating the skills of university graduates with the participation of employees

Authors

Erkhemtsog, J¹., Bayarmaa,

G²., Bayarmunkh, G³

¹Innovation Center for

Creative Industries,

Mongolian State University of

Arts and Culture,

Abstract

This study aimed to elucidate whether the skillsets possessed by university graduates align with the expectations of employers. A sample of 300 individuals, comprising directors and senior-level managers from various enterprises and organizations, actively participated in our comprehensive survey. To ensure a representative sample, we categorized survey participants into five intervals based on their

²Mongolian State University
of Arts and Culture,

³Education Policy and
Planning Research Sector,
Mongolian National Institute
for Educational Research

Keywords:

general skills of graduates,
employers and skill levels

enterprise's workforce size. Our questionnaire design prioritized ease of completion and utilized a multidimensional evaluation approach.

The skills of university graduates underwent evaluation through 15 indicators encompassing common competencies and essential abilities for productive employment. Subsequently, the assessment results were grouped into five intervals. We employed statistical software for data analysis and applied the weighted average method to evaluate the outcomes.

Our research focused on discerning the desired skill levels sought by employers versus the current proficiency levels of university graduates. In our findings, it became evident that there exists a general skill deficit among university graduates. Specifically, in areas such as foreign language proficiency (2.43) and creative thinking (2.88), graduates demonstrated inadequacies. However, their competencies in other areas ranged from average to commendable, with scores ranging from 3.16 to 3.97.

Consequently, to bridge this gap and align university graduate skills with employer expectations, we propose the establishment of a legal framework and economic incentives to facilitate employer involvement in shaping training programs and evaluating training quality. Collaboration initiatives between educational institutions and employers must also be prioritized. In conclusion, it is imperative to foster a more robust partnership between educational institutions and employers to enhance the relevance of university curricula and ensure that graduates are well-prepared for the demands of the job market.

Оршил

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар нийт хөдөлмөрийн насны хүн амын 52.7 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 24.8 хувь байна. (ХНХСИ, 2015). Мөн залуучууд хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ур чадвар эзэмшээгүйгээс ажил эрхлэлт дээр бэрхшээл үүсэж байна. Хөдөлмөрийн зах зээлд бэлтгэгдэн гарч байгаа төгсөгчдийн ур чадвар муу байгаагаас сургуулиа төгсөөд ажилгүй байгаа залуусын тоо нэмэгдэж байна. (ILO, 2017). Хөдөлмөрлөх хүсэлтэй хүмүүсийн чадвар эрэлтэд нийцэхгүй, дутагдалтай байна. Оюутан, залуучуудад хөдөлмөрийн зах зээлд гарахад нь шаардагдах мэдлэг, ур чадварыг хангалттай олгож чадахгүй байна. (Монгол улсын хүний хөгжлийн илтгэл, 2016). Мөн Бакалаврын зэргээр суралцагсдын тоо 2045 он гэхэд 64 хувиар өсөх магадлалтай. Ихэнх хувийг худалдаа бизнесийн чиглэлээр (сүүлийн 18 жилийн үндсэн дээр) суралцагсад байна. (ҮСХ, 2019).

Дээрх судалгаа нь монгол улсын их дээд сургууль төгсөгчдийн ажил эрхлэлтийн боломж хязгаарлагдмал эсвэл төгсөгчид мэргэжлийн ур чадвар ажлын байрны эрэлтэд нийцээгүй болохыг илэрхийлж байна. Нээлттэй ажлын байрны хувьд хөдөлмөрийн чадвар нь боловсрол түвшинтэй холбоотой гэж судлаачид үзжээ. Өндөр чадвартай нэг ажилтны бүтээмж нь чадвар муутай ажилтныхаас их байдаг учир боловсрол нь хөдөлмөрийн чанар болон бүтээмжид нөлөөлдөг гол хүчин зүйл гэж олон эрдэмтдийн бүтээлд дурджээ. (ҮСХ. Боловсрол ба хөдөлмөр эрхлэлт, 2020). Мөн сургуульд сурсан хүн нэг жилээр нэмэгдэхэд

Энэ нь ажил эрхлэлтийн эрэлтэд тохирсон төгсөгчдийг бэлтгэх, дээд боловсролтой төгсөгчдийн ажилд ороход шаардлагатай ур чадварыг хөгжүүлж чадаагүйг харуулж байна.

Судлагдсан байдал

Судлаачид их дээд сургуулиудын төгсөгчдийн ур чадвар ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд хэрхэн нийцэж байгаа талаар дүгнэлт бүхий олон судалгаа хийгдсэн байдаг. Жишээлбэл, их, дээд сургууль төгсөгчдийн 58.5% нь ажил үүрэг болон мэргэжлийн нийцтэй түвшнээр “тохирдог”, “маш сайн тохирдог” гэсэн үнэлгээ авч төгсөгчдийн талаас илүү хувь нь эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажиллаж байгаа нь тогтоогджээ. Ажлын байранд гүйцэтгэж буй ажил үүрэг нь эзэмшсэн мэргэжлээс өөр чиглэлээр ажиллаж буй дундаж нь (20.5%) байгаа юм. Ялангуяа дээд боловсролын салбарын нийгмийн халамж-хангамж (42.9%), тээвэр (36.1%), хууль эрх зүй (32.3%) хүмүүнлэгийн ухаан (32.1%) байгаль хамгаалал (31.6%)-ийн мэргэжилтнүүд нь мэргэжлийн бус хөдөлмөр эрхлэлттэй байна. (Боловсрол ба ажил эрхлэлт, 2019) гэсэн үр дүн байна. Эндээс их дээд сургууль төгсөгчдийн ур чадвар нь ажил үүрэг болон мэргэжлийн нийцтэй түвшнээр “тохирдог” гэсэн үнэлгээ 58,5%, боловч, зарим мэргэжлийн нийцтэй түвшин доогуур байгаа нь цаашид судлах шаардлагатай болохыг илэрхийлж байна.

Судалгаанд их дээд сургууль төгсөгчдөд эзэмшүүлэх шаардлагатай 15 ерөнхий ур чадварыг сонгон оруулсан. Орчин үед хөдөлмөр эрхлэлтийн талаарх онол нь хүмүүсийн эдийн засгийн сайн сайхан байдал, улс орнуудын өрсөлдөх чадвар нь ажиллах хүчний мэдлэг, ур чадвар, аж ахуйн нэгжээс шалтгаалдаг болсон гэсэн таамаглал дээр тулгуурладаг. Тухайлбал төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх орчин үеийн зөвшилцөл ба зөрчилдөөний онолыг (Браун нар, 2002), боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн харилцааны өөрчлөлтийг үзэл баримтлалд оруулж ирсэн. Энэ онол нь дээд боловсролын түвшинд ерөнхий ур чадвар эзэмшүүлэх замаар хүний хөгжлийг дэмжиж төгсөгчдийн ажлын байрыг хангах нь компанийн хөгжлийг хурдасгах болно гэсэн итгэл дээр суурилдаг. Зөвшилцлийн онол нь сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтад хэрэгжүүлэхдээ төгсөгчдөд хангалттай ерөнхий ур чадварыг суулгаагүйд академик болон их сургуулийг буруутгах хандлагатай байдаг.

Ийнхүү хөдөлмөрийн зах зээлийн зөрчилдөөнд ажил олгогчийн эрэлхийлсэн ерөнхий ур чадварыг эзэмшүүлэхэд ажил олгогчийн гүйцэтгэх үүрэг оролцоо байхгүй, нөгөө талаас сургалтын байгууллага ажил олгогчдын санал болгож буй ур чадвар эзэмшүүлэхгүй байгаа талаар маргаан үргэлжилж ажил олгогч сургуулиудын хоорондын зөрчилдөөн үүсдэг. Зөрчилдөөний онол нь төгсөгчдийг ажлын байраар хангах дадлага туршлагатай болохын тулд ажил олгогчид хариуцлага хүлээх ёстой бөгөөд үүрэг хариуцлагыг зөвхөн их дээд сургуулиудад оноох ёсгүй гэж үздэг.

Манай улсын боловсролын тогтолцооны хувьд ажил олгогч их дээд сургуулийн хамтын оролцоог чиглүүлсэн хууль зүйн үндэслэл хангалтгүй байна. Тухайлбал: ”Дээд боловсролын сургалтын байгууллага “Ажил олгогчдын захиалга, санхүүжилтээр оюутан сургах, сургалт судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих сан”-тай байна. (Дээд боловсролын тухай хууль, 2002), -т ажил олгогчтой холбоотой нэг заалт. Мөн хуулийн 9.1.-т “ Их сургууль, дээд сургууль, коллежид суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үнэлж, дүгнэнэ” гэсэн заалт оруулсан.

Ажил олгогчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх үүрэг нь их дээд сургууль, ажил олгогчдын хамтын хариуцлага байсаар байна. Иймээс Монгол орны хөдөлмөрийн зах зээлийн ур чадварын зөрүүтэй холбоотой ажил олгогчдын хэтийн төлөвийг судалж, зөрүүг арилгахад хариуцлага хүлээх оролцогч талуудыг судлах шаардлагатай байгаа юм.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаа нь их дээд сургуулийн төгсөгчдийн ур чадвар ажил олгогчдын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэсэн. Үүний тулд судалгааны асуулгыг дэс дараалалтай, энгийн байх зарчмыг баримтлан олон хэмжээст үнэлгээний арга болон болон бусад тоон аргуудыг хэрэглэсэн.

Судалгааны түүвэр сонгох. Монгол улсын статистикийн бизнес регистрийн санд 2021 онд 230.6 мянган аж ахуйн нэгж, байгууллага, бүртгэлтэй байгаагийн 81.5 мянга буюу 35.4 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс аж үйлдвэрийн салбарт 2021 онд 18.5 мянган ААНБ бүртгэлтэй байгаагаас 6.8 мянган ААНБ буюу 36.6 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. (ҮСХ, 2021) Судалгаанд аж ахуйн нэгж байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүн хамруулсан. Асуулгад судалгааны түүврийн зохистой хэмжээг сонгохдоо практикт түгээмэл ашигладаг, түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэхэд энгийн зорилтод түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцсон

$$n = \frac{z^2 \cdot p \cdot (1-p)}{e^2}$$

$$n = \frac{z^2 \cdot p \cdot (1-p)}{e^2}$$

Энд n - эх олонлогийг төлөөлөх зохистой түүврийн хэмжээ, $z=1.96$ - 95 хувийн итгэх түвшин дэх t статистикийн тархалтын утга, $p=0.5$ -түүврийн хэмжээг тооцоход ашиглах үндсэн үзүүлэлтийн эх олонлогт эзлэх хувийн жин буюу илрэх магадлал, $e=0.05$ - түүврийн стандарт алдаа буюу нарийвчлал, $N=1.53$ сая хүн –эх олонлогийн хэмжээ буюу 20-60 насны хүн амын тоо.

Судалгааны асуулгын дэс дараалалтай, бөглөхөд хялбар байх зарчмыг баримтлан олон хэмжээст үнэлгээний аргыг ашиглаж, тухайн хариултыг сонгох хувийн жин: $(P'_1:P'_2:...P'_n)$, тэдгээрийн эх олонлогт харгалзах хувийн жин: $(P_1:P_2:...)$ нөхцөлийг $|1- \beta|$ магадлалтай хангаж байх түүврийн зохистой хэмжээг тодорхойлох нь чухал юм.

$$\{|P_1 - P'_1| \leq e, |P_2 - P'_2| \leq e, \dots |P_n - P'_n| \leq e \}$$

Судалгааны мэдээллийг статистикийн программ хангамжаар боловсруулж судалгааны үр дүнг ашиглан чанарын үнэлгээ хийхдээ жигнэсэн дунджийн аргыг ашигласан ба дараах томъёогоор тооцсон.

$$X = \sum_{i=1}^n \frac{(X_i \cdot P_i)}{X_i}$$

Энд Х- дундаж хэмжигдэхүүн буюу чанарын оноо, P_i -үзүүлэлтүүдийн ач холбогдлын түвшин, X_i -тухайн үзэгдлийн давтамж буюу судалгааны үр дүн.

Энэхүү судалгаанд их, дээд сургуулийн төгсөгчдийн ур чадварыг Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл шатлал (5- маш сайн, 4 сайн, 3 дунд, 2 муу, 1 маш муу) - аар үнэлсэн.

Судалгаанд оролцогчдын мэдээлэл: Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүн хамрагдсанаас 20 хүн буюу 6.61% нь 1-5 хүнтэй, 35 хүн буюу 11.8% нь 6-19 хүнтэй, 46 хүн буюу 15.3% нь 20-49 хүнтэй, 64 хүн буюу 21.2% нь 50-149 хүнтэй, 136 хүн буюу 45.2% нь 150-дээш ажилтантай аж ахуйн нэгжид тус тус ажилладаг байна. Судалгааны түүвэрлэлтийг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж доорх хүснэгтээр харуулав.


Судалгааны хэрэгсэл боловсруулах: Судалгааны асуулгат их дээд сургуулийн төгсөгчдийн ур чадварыг Ликертийн хэмжүүрээр 5 хүртэл шатлал (5-маш сайн, 4- сайн, 3- дунд, 2- муу, 1-маш муу)-аар хэмжинэ. Мөн аж ахуйн нэгжийн түүвэрлэлтийг ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж төгсөгчдийн ерөнхий ур чадварын 15 үзүүлэлтээр i) ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин ii) төгсөгчдийн өнөөгийн ур чадварын түвшин гэсэн байдлаар үнэлсэн. Ерөнхий ур чадварын нэгдсэн үнэлгээг хүснэгтээр, ур чадварын зөрүүний шинжилгээг зургаар тус тус нэгтгэн харуулав.

Судалгааны мэдээлэл цуглуулах: Судалгаанд аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүн хамрагдсанаас 20 хүн буюу 6.61% нь 1-5 хүнтэй, 35 хүн буюу 11.8% нь 6-19 хүнтэй, 46 хүн буюу 15.3% нь 20-49 хүнтэй, 64 хүн буюу 21.2% нь 50-149 хүнтэй, 136 хүн буюу 45.2% нь 150-дээш ажилтантай аж ахуйн нэгжид тус тус ажилладаг байна. Судалгааны түүвэрлэлтийг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагчдын байдал

№	Ажиллагчдын тооны	ААНБ-ийн эзлэх хувь	Ажиллагчдын тоо, мян.хүн	Дүнд эзлэх хувь	хэмжээ
	Нийт	100	546.4	100	300

Их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын үнэлгээ: Их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварыг 15 үзүүлэлтээр i) ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин, ii) төгсөгчдийн өнөөгийн ур чадварын түвшин гэсэн байдлаар үнэлж, үр дүнг зурагт харуулав.



Тайлбар: 5-маш сайн, 4-хангалттай, 3-дундаж, 2-хангалтгүй, 1-маш муу

Дээрх зургаас харвал, ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшинг 4.13- 4.97 байх шаардлагатай гэж тодорхойлжээ. Харин их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын өнөөгийн түвшинг гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийн хувьд хангалтгүй, харин бусад ур чадваруудын хувьд дундаж буюу 3.16-3.97 байдаг гэж үнэлсэн байна.

Их, дээд сургууль төгсөгчдийн ур чадварт зөрүүний шинжилгээг ажил олгогчдын хүсэж буй ур чадвар болон төгсөгчдийн өнөөгийн ур чадварын үнэлгээний үр дүнд тулгуурлан хийвэл:

- 1-5 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд бие даан ажиллах (1.51), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.45), цаг төлөвлөх, баримтлах (1.45) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин гадаад хэлний мэддэг хангалтгүй (2.86) гэж,
- 6-19 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.89), цаг гадаад хэлний мэдлэг (1.60), манлайлах (1.14) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.00), гадаад хэлний мэдлэг (2.09), албан бичиг боловсруулах (2.77) зэргийг хангалтгүй гэж,
- 20-49 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд манлайлах (2.12), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.70), компьютер дээр ажиллах (1.54) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин манлайлах (2.31), гадаад хэлний мэдлэг (2.31), асуудалд хариуцлагатай хандах (2.83), албан бичиг боловсруулах (2.87) зэргийг хангалтгүй гэж,
- 50-149 ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд асуудалд хариуцлагатай хандах (2.57), цаг төлөвлөх, баримтлах (2.16), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.14) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.86), цаг

төлөвлөх, баримтлах (2.84), асуудалд хариуцлагатай хандах (2.43), гадаад хэлний мэдлэг (2.38) зэргийг хангалтгүй гэж,

- 150-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад хэлний мэдлэг (1.91), манлайлах (1.56), онолын мэдлэгийн түвшин (1.45) зэрэг үр чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин онолын мэдлэгийн түвшин (2.88), гадаад хэлний мэдлэг (2.50) зэргийг хангалтгүй гэж тус тус үнэлэгджээ.

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад хэлний мэдлэг (1.70), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.64), манлайлах (1.41) зэрэг үр чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийг хангалтгүй гэж үнэлжээ.


Их, дээд сургууль төгсөгчдийн үр чадварыг 15 үзүүлэлтээр үнэлж, үр дүнг аж ахуйн нэгжийн ажиллагчдын тоонд тулгуурлан 5 интервалд багцалж, үр дүнг дараах байдлаар нэгтгэн харуулав. Үүнд:

- их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий үр чадварын нэгдсэн үнэлгээг хүснэгтээр,
- их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий үр чадварын зөрүүний шинжилгээг зургаар

Хүснэгт 2. Их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий үр чадварын нэгдсэн үнэлгээ

№	Үр чадварууд	Үр чадварын үнэлгээ ба ажиллагчдын тоо															Нэгдсэн үнэлгээ		
		1-5			6-19			20-49			50-149			150+			Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү
		Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү	Ажил олгогч	Төгсөгч	Зөрүү			
1	Мэргэжлийн үр чадвар	4.77	3.98	0.79	4.93	3.88	1.1	4.86	4.69	0.17	5.00	3.1	1.86	5.00	3.86	1.14	4.97	3.86	1.11
2	Багаар ажиллах	4.00	3.57	0.43	4.11	3.38	0.7	4.33	4.25	0.08	4.49	3.7	0.75	5.00	3.75	1.25	4.63	3.78	0.85
3	Манлайлал	4.00	3.29	0.71	4.52	3.38	1.1	4.43	2.31	2.12	4.43	3.5	0.92	4.81	3.25	1.56	4.60	3.19	1.41
4	Асуудал хариуцлагатай ханд	4.49	3.74	0.75	4.38	3.28	1.10	3.85	3.83	0.02	5.00	2.4	2.57	4.56	4.00	0.56	4.53	3.55	0.98
5	Бүтээлч хандлага сэтгэлгээ	4.71	3.26	1.45	3.89	2.00	1.9	4.70	3.00	1.7	5.00	2.86	2.14	4.33	3.00	1.33	4.52	2.88	1.64
6	Компьютер дээр ажиллах	4.00	3.29	0.71	4.21	3.56	0.7	4.74	3.2	1.54	4.54	4.4	0.11	4.51	3.38	1.13	4.50	3.60	0.9
7	Интернет орчинд ажиллах	4.00	3.29	0.71	3.91	3.90	0	4.00	3.66	0.34	4.85	4.4	0.42	4.66	3.56	1.10	4.48	3.79	0.69
8	Харилцааны соёл	4.00	3.00	1.00	4.32	3.55	0.8	4.86	3.85	1.01	4.54	3.9	0.62	4.33	4.25	0.08	4.45	3.97	0.48
9	Ес зүйн төлөвшил	4.54	3.64	0.9	4.00	3.67	0.3	4.07	3.92	0.15	4.71	2.9	1.85	4.52	3.75	0.77	4.45	3.58	0.87
10	Цаг төлөвлөх, баримтлах	4.71	3.26	1.45	4.52	3.84	0.7	4.31	3.77	0.54	5.00	2.8	2.16	4.11	3.63	0.48	4.43	3.49	0.94
11	Бие даан ажиллах	4.75	3.24	1.51	4.59	3.63	1	4.32	3.54	0.78	5.00	4.7	0.29	4.11	2.86	1.25	4.43	3.48	0.95
12	Техник хэрэгсэл ашиглах	4.00	3.00	1.00	4.38	3.84	0.5	3.82	3.80	0.02	4.38	4.3	0.09	4.71	3.69	1.02	4.43	3.82	0.61
13	Албан бичиг боловсруулах	4.71	3.90	0.81	3.86	2.77	1.1	3.69	2.87	0.82	4.38	3	1.35	4.66	3.28	1.38	4.38	3.16	1.22
14	Онолын мэдлэгийн түвшин	3.90	3.57	0.33	4.48	3.66	0.8	4.14	4.00	0.14	4.31	3.5	0.82	4.33	2.88	1.45	4.30	3.33	0.97
15	Гадаад хэлний мэдлэг	4.00	2.86	1.14	3.69	2.09	1.60	3.57	2.31	1.26	4.14	2.4	1.76	4.41	2.50	1.91	4.13	2.43	1.70
	Дундаж үзүүлэлт	4.31	3.39	0.91	4.25	3.36	0.89	4.25	3.53	0.71	4.65	3.47	1.18	4.54	3.44	1.09	4.48	3.46	1.02

Тайлбар: 5-маш сайн, 4-хангалттай, 3-дундаж, 2-хангалтгүй, 1-маш муу



Чадварлаг хүний нөөц бэлтгэх чиглэлээр хамтын ажиллагааг хөгжүүлэх

Судалгаанд хамрагдсан ажил олгогчдын хувьд байгууллагад шаардлагатай ур чадвар бүхий хүний нөөцийг бэлтгэн авах зорилгоор их, дээд сургуулиудтай хамтран ажиллах боломжийг нээлттэй байдлаар асуухад i) хамтарсан төсөл хэрэгжүүлэх гэж 55.2%, ii) оюутан дадлагажуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэж 51.4%, оюутнуудыг дадлагажуулж ажилд авах гэж 37.8%, iv) сургалтын лаборатори, түшиц газар болох гэж 34.8% нь тус тус тодорхойлжээ. Судалгааны үр дүнг нэгтгэн зурагт харуулав.



Дүгнэлт, санал

1. “Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ хийх онол, арга зүйн үндэслэл” сэдэвт суурь судалгааны хүрээнд их, дээд сургууль төгсөгчдийн ур чадварын төлөв байдлыг тогтоох зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагын захирал, удирдах түвшний менежерүүд болох 300 хүнийг хамруулан судалгаа явууллаа.
2. Судалгааны үр дүнгээс ажил олгогчдын хүсэж буй ур чадварын түвшин 4.13- 4.97 байгаа бол их, дээд сургууль төгсөгчдийн ерөнхий ур чадварын өнөөгийн түвшинг гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийн хувьд хангалтгүй, харин бусад ур чадваруудын хувьд дундаж буюу 3.16-3.97 байдаг гэжээ.
3. Харин аж ахуйн нэгжүүдийн хувьд гадаад хэлний мэдлэг (1.70), бүтээлч хандлага, сэтгэлгээ (1.64), манлайлах (1.41) зэрэг ур чадваруудын хувьд зөрүү хамгийн их, харин гадаад хэлний мэдлэг (2.43), бүтээлч хандлага, сэтгэлгээ (2.88) зэргийг хангалтгүй гэж үнэлжээ.
4. Их дээд сургууль ба аж олгогчдын түншлэлийг хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар олгох сургалтын хөтөлбөрийг хамтран боловсруулж хэрэгжүүлэх боломж бүрдүүлэх

5. Оюутан залуучуудыг суралцаж буй мэргэжлийн чиглэлээр ажлын байранд дадлагажуулах цагийн болон түр ажлын байранд тогтмол зуучлах, төгсөгчдийг ажлын байраар хангах чиглэлээр аж ахуйн нэгж байгууллагуудыг үүрэг, хариуцлага оноох, урамшуулах
6. Их, дээд сургуулийн сургалтын чанарын үнэлгээний системийг төлөвшүүлэхэд суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар нь ажил олгогчдын шаардлагыг хангаж байгааг тогтоох хөндлөнгийн үнэлгээг тогтмолжуулах, улмаар ажил олгогчдын төлөөллийн оролцоог хангах, тэдний идэвх санаачилгыг дэмжихэд анхаарах шаардлагатай байна.

Ном зүй.

Браун нар. (2002). *Employability in a Knowledge-Driven Economy*.

ILO. (2017). *Jobs and skills for youth*.

Боловсрол ба ажил эрхлэлт . (2019). <https://jargaldefacto.com/article/bolowsrol-ba-ajil-erkhlelt>.

Дээд боловсролын тухай хууль. (2002). *12.3-р зүйл*. Улаанбаатар хот: УИХ.

Монгол улсын хүний хөгжлийн илтгэл. (2016). *UNDP*.

ҮСХ. (2019). *Дээд боловсролын үндсэн үзүүлэлтүүдийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ*.

ҮСХ. (2021). *АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА*. УБ.

ҮСХ. Боловсрол ба хөдөлмөр эрхлэлт. (2020). Улаанбаатар хот.

ХНХСИ. (2015). *Хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлын судалгаа*.

Эрхэмтөгс Ж. "Монгол улсад соёлын бүтээлч үйлдвэрлэл хөгжүүлэх арга зам" Бизнесийн удирдлагын ухааны доктор (Ph.D) -ын дисс. УБ., 2016

Хөдөлмөрийн зах зээлийн зарим үзүүлэлтүүд. УБ СЕГ, 2016

Соёл урлагийн Их сургуулийн төгсөгчдийн судалгааны тайлан, СУИС, 2017

"Соёл урлагийн салбарын хүний нөөцийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв" (2018-2023) төслийн тайлан БСШУСЯ, 2018

www.1212.mn